



БАГАНУУР ХК

2025

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН



АГУУЛГА

- Компанийн танилцуулга
 - Алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн мэндчилгээ
 - Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
 - Компанийн бүтэц
 - Хүний нөөц
 - Үйл ажиллагааны үр дүн
 - Санхүүгийн үр дүн
 - Худалдан авалтын үр дүн
 - Хөрөнгө оруулалтын үр дүн
 - Төсөл хөтөлбөрүүд
 - Компанийн засаглал
 - Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй
 - Байгаль орчны хяналт, нөхөн сэргээлт
 - Онцлох үйл явдлууд
 - Санхүүгийн тайлан
-



КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Компанийн оноосон нэр
Үүсгэн байгуулагдсан он
Компанийн албан ёсны хаяг
Үйл ажиллагааны чиглэл
Бүртгэгдсэн бирж
Компанийн нийт гаргасан хувьцааны тоо
Компанийн удирдлага
Ажилтнуудын тоо
Үйлдвэрлэлийн хүчин чадал
Томоохон нийлүүлэгч байгууллага

"БАГАНУУР" ХУВЬЦААТ КОМПАНИ

1978 ОН

Монгол улс, Улаанбаатар хот, Багануур Дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн хэсэг, "Багануур" ХК-ийн байр

- Нүүрс олборлох, борлуулах, боловсруулах,
- Алтны шороон ордыг ашиглах
- Сувилал, хоол үйлдвэрлэл
- Гадаад худалдаа

Монголын хөрөнгийн бирж

20,974,360 ширхэг

ТУЗ-ийн дарга:
ПҮРЭВДОРЖИЙН БАТТӨР

Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч:
ТЭРБИШИЙН ОТГОНБОЛД

1122

Жилд **4.0 сая** тонн нүүрс олборлох, борлуулах

- "ДЦС-4" ТӨХК,
- "ДЦС-3" ТӨХК,
- "ДЦС-2" ТӨХК,
- "Амгалан ДС" ТӨХК
- "Эрдэнэт ДЦС" ТӨХК,
- "Дархан ДЦС" ТӨХК
- "Багануур ДС" ТӨХК
- Орон нутгийн дулааны станцууд

КОМПАНИЙН ТУХАЙ

“Багануур” ХК нь Монгол улсын төвийн бүсийн эрчим хүчний гол нийлүүлэгч уурхай юм.

Багануурын уурхайн нүүрс олборлолтын жилийн хүчин чадал 4.0 сая.тн боловч өнөөдрийн байдлаар дотоодын хэрэглэгчдийн нүүрсний хэрэгцээнээс хамаарч жилд 4.9 сая.тн нүүрс олборлож төслийн хүчин чадлыг 22.5%-аар нэмэгдүүлэн Монгол Улсын эрчим хүчний нүүрсний хэрэглээний 47 хувь, төвийн бүсийн хэрэглэгчдийн 52 хувийг дангаараа хангаж байна.

Тус уурхай дараах станцуудыг нүүрсээр хангадаг.

- “ДЦС-4” ТӨХК нүүрсний хэрэгцээний 50%,
- “ДЦС-3” ТӨХК 100%
- “ДЦС-2” ТӨХК 100%,
- “Дархан”, “Эрдэнэт” ДЦС 10-30%,

Мөн Багануур, Төв аймаг, Сэлэнгэ, Хөтөл тосгоны дулааны станцууд болон уурын зуухнуудыг 100% эрчим хүчний нүүрсээр ханган ажиллаж байна.

Нүүрсний орд нь зүүн хойноос баруун урагш чиглэсэн суналтын дагуу уртаараа 12 км, өргөнөөрөө 4-5 км талбай эзэлж мульд маягаар тогтсон үндсэн 3 давхаргаас


бүрдэнэ.

Нүүрсний чанарын үзүүлэлт:

Багануурын нүүрс нь эрчим хүчний зориулалттай Б2 маркийн нүүрсэнд хамаарна.

- Нүүрсний үнслэг нь 12-17%,
- чийглэг нь 28-33%,
- хүхрийн агуулга нь 0.4%,
- дулаан гаргах илчлэг нь 3200-3600 ккал/кг

1978 онд баталсан тооцоогоор нүүрсний нөөц 599.0 сая.тн 1988 онд нарийвчилсан хайгуул хийж ордын баялаг нөөцийг 708.2 сая.тн болгосон. Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар 2014-2015 онд Багануурын нүүрсний ордын гүйцээх хайгуулын ажил хийгдэж балансын нөөцийг 280.0 сая.тн-оор нэмэгдүүлж Олон улсын JORC стандартаар үнэлэгдсэн нийт 812.0 сая.тн баталгаат нүүрсний нөөцтэй болсон. Шинээр нөөц батлагдсанаас хойш 49.2 сая.тн нүүрс олборлон борлуулж одоогийн байдлаар 762.8 сая.тн нүүрсний нөөцтэй байна.



АЛСЫН ХАРАА

Монгол Улсын нүүрсний салбарын чиг хандлагыг тодорхойлогч байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО:

Тогтвортой хөгжлийг хангасан, мэдлэг инновацад суурилсан үндэсний тэргүүлэгч компани болно.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, хамтран ажиллагч түншүүд, нийт ажилтан, албан хаагчид аа, Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

“Багануур” ХК нь Монгол Улсын эрчим хүчний салбарын тогтвортой, найдвартай ажиллагааг хангах стратегийн чухал үүргийг олон жилийн турш нэр төртэйгөөр гүйцэтгэж ирсэн үндэсний хэмжээний томоохон уурхайн нэг билээ. Манай компани төвийн бүсийн эрчим хүчний хэрэглээний гол эх үүсвэрийг бүрдүүлж, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулсаар байна.

Компанийн хувьд 2025 он нь сорилт, боломжийг хослуулсан, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, техник технологийн шинэчлэлийг эрчимжүүлэх, санхүүгийн сахилга батыг бэхжүүлэх чиглэлд бодит ахиц гарсан онцлог жил байлаа. Уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл тогтвортой хангагдаж, олборлолт, хөрс хуулалтын үндсэн үзүүлэлтүүд төлөвлөгөөний түвшинд хэрэгжиж, компанийн үйл ажиллагаа тасралтгүй үргэлжилсэн нь ТУЗ, гүйцэтгэх удирдлага, нийт хамт олны нэгдсэн хүчин чармайлтын үр дүн юм.

Тайлант хугацаанд компанийн санхүүгийн үзүүлэлтүүдэд эерэг өөрчлөлт гарч, ашигт ажиллагаа сайжирсан нь компанийн засаглал, шийдвэр гаргалтын чанар дээшилж, үйл ажиллагааны зохион байгуулалт оновчтой болж байгааг илтгэж байна. Мөн олон жилийн турш хуримтлагдсан өр төлбөрийг бууруулах, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх чиглэлд тодорхой ахиц гарсан нь онцлох үр дүн боллоо.

Түүнчлэн компанийн техник, технологийн шинэчлэл, дэд бүтцийн хөрөнгө оруулалт, томоохон төслүүдийн бэлтгэл ажлыг эрчимжүүлж, цаашид олборлолтоос боловсруулалт руу шилжих, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх стратегийн зорилтуудыг тодорхойлон ажилласан нь компанийн ирээдүйн өсөлтийн суурийг тавьж байна.

ТУЗ нь тайлант хугацаанд компанийн стратегийн удирдлага, хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, бодлогын шийдвэрүүдийг оновчтой гаргах, засаглалын тогтолцоог бэхжүүлэхэд онцгой анхаарч ажиллалаа. Мөн ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэн, санхүү, засаглал, хүний нөөцийн чиглэлд мэргэжлийн дүгнэлт, зөвлөмжийг тогтмол гарган ажилласан болно.

Цаашид компанийн үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлага, санхүүгийн сахилга бат, мэдээллийн илтөд байдлыг улам боловсронгуй болгох шаардлага байгааг ТУЗ онцгойлон анхаарч байна.

Иймд ирэх хугацаанд засаглалын бодлого, хяналтын тогтолцоог улам сайжруулж, эрсдэлийг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх болно.

Цаашид “Багануур” ХК нь эрчим хүчний салбарын өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах, олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник технологийн шинэчлэлийг үргэлжлүүлэх, байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжлийн зарчмыг баримтлан үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Компанийн амжилт бүтээлд үнэтэй хувь нэмэр оруулж буй нийт ажилтан, албан хаагчид, хамтран ажиллагч байгууллагууд, хувьцаа эзэмшигчид Та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Та бүхний итгэл, дэмжлэг, хамтын ажиллагааны үр дүнд бид цаашид ч тогтвортой өсөлтийг хангаж, илүү өндөр амжилтад хүрнэ гэдэгт итгэлтэй байна.

Хүндэтгэсэн:
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
П.БАТТӨР

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, хамтран ажиллагч байгууллагууд, нийт ажилтан албан хаагчид та бүхнийхээ амрыг эрэн мэндчилье.

“Багануур” ХК нь Монгол Улсын эрчим хүчний салбарын тогтвортой, найдвартай ажиллагааг хангах чухал үүргийг 48 жилийн турш нэр төртэйгөөр биелүүлж ирсэн стратегийн ач холбогдолтой чухал уурхай юм.

Манай хамт олон нь хариуцлага, ёс зүй, мэргэжлийн ур чадвар, шилдэг техник технологид тулгуурлан улс орны эрчим хүчний нүүрсний хэрэгцээг хангах эрхэм зорилгоо амжилттай хэрэгжүүлсээр байна.

Өнгөрсөн жил манай компанийн хувьд хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, техник технологийг сайжруулах, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх чиглэлд бодит ахиц дэвшил гарсан жил байлаа.

Манай хамт олон нь 2025 онд дэвшүүлсэн зорилт, уулын ажлын төлөвлөгөөгөө үзүүлэлт тус бүрээр 100-104 хувиар давуулан биелүүлж, 2025 оны жилийн эцсийн байдлаар 4.8 сая тонн нүүрс олборлон борлуулж, улсын төсөвт 105.5 тэрбум төгрөгийн татвар, Нийгмийн даатгалд 19.2 тэрбум төгрөг, үндэсний баялгийн санд 126.3 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн. 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн МУЗГ-ын хуралдааны 30 дугаар тэмдэглэлээр хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах, өрийг хувьцаа хэлбэрт шилжүүлэх чиглэл, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дэмжлэгтэйгээр олон жилийн турш хуримтлагдсан татварын өр 64.1 тэрбум төгрөг, 1997, 1998 онд үүссэн Мог, Мон-Пи зээлийн үлдэгдэл 29.9 тэрбум төгрөгийн өр төлбөрүүдийг амжилттай барагдуулан, татвар төлөхийн өмнөх ашиг 2.7 тэрбум, татварын дараах цэвэр ашиг 1.9 тэрбум төгрөгийн ашигтай

НИЙТ ОЛБОРЛОЛТ
4.8 САЯ.ТН
ЦЭВЭР АШИГ
1.9 ТЭРБУМ

ажиллалаа.

Мөн компанийн өөрийн хөрөнгө оруулалтаар хөрс хуулалтын өндөр хүчин чадалтай Liebherr 9250 маркийн 15м³-ийн шанагатай шууд утгуурт цахилгаан экскаватораар техникийн шинэчлэл хийлээ.

Бид бүхэн “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс ҮТП” ХХК-тай хамтран дунд хугацаанд хэрэгжүүлэх 2 томоохон төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг хийж дуусгалаа. Багануурын уурхайг түшиглэн байгуулах “Нүүрс-химийн цогцолбор”-ийн талбайг 2 байршилд нийт 636 га газрыг ЗГ-ын 2025 оны 03-р сарын 20-ны тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авч, Багануур ҮТП-ийн ерөнхий төлөвлөлт болон ТЭЗҮ-ийг БНХАУ-ын төрийн өмчит “Сэдин инженеринг Монголиа” компани боловсруулан дуусгаж АҮЭБЯ-ны ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн батлууллаа.

Мөн “Нүүрс бутлан ачих байгууламж” №03-ийг шинээр барих төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг “Соёолон инженеринг” ХХК гүйцэтгэж дуусгалаа.

“Багануур” ХК хөдөлмөрийн аюулгүй байдал, ажилтнуудын нийгмийн баталгааг хангах асуудлыг нэн тэргүүнд тавьж ISO 45001:2018 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо” стандарт шаардлагын хүрээнд магадлан аудит хийлгэн, стандартын баталгаажуулалтын гэрчилгээг сунгаж, Олон улсын ISO 27001:2022 “Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо стандарт”-ыг хэрэгжүүлэх зорилго тавин ажиллаж байна.

Уурхайчин хамт олныхоо хамтын оролцоотойгоор ирэх ондоо Амины орон сууцны зориулалтаар 2.2 га, нийтийн орон сууцны зориулалттай 1.1 га газарт “УУРХАЙЧИН ОРОН СУУЦ ХӨТӨЛБӨР” хэрэгжүүлэхээр, “ЭРҮҮЛ УУРХАЙЧИН ХӨТӨЛБӨР”-ийн хүрээнд Эрүүл мэнд хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлж БНСУ-ын Тэжон хотод эрүүл мэндийн багц үйлчилгээнд хамруулах, 2026-2027 онуудад хэрэгжүүлэх хамтын гэрээний хүрээнд 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс үндсэн цалинг 10%-аар нэмэгдүүлэх зэрэг бодлогын томоохон ажлуудыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна

Компанийнхаа амжилт бүтээлд үнэтэй хувь нэмэр оруулж буй алтан уурхайчид, хамтран ажиллагч түншлэгч байгууллагууд болон биднийг үргэлж дэмжин ажилладаг иргэддээ чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Та бүхнийхээ хүчин чармайлт, итгэл дэмжлэгийн үр дүнд бид улам их амжилтыг хамтдаа бүтээнэ гэдэгт итгэлтэй байна.

Татварын хуримтлагдсан өр төлбөрийг шийдвэрлэлээ.

64.1 ТЭРБУМ

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн дэмжлэгээр өр төлбөрийг бууруулсан.

29.9 ТЭРБУМ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т. ОТГОНБОЛД

НҮҮРС ОЛБОРЛОЛТ /МЯН.ТН/

4830.7 100.1%

НҮҮРС БОРЛУУЛАЛТ /МЯН.ТН/

4844.8 100.4%



ХӨРС ХУУЛАЛТ /МЯН.М³/

22889.7 102.6%


НИЙТ УУЛЫН АЖИЛ /МЯН.М³/

33562.1 104.2%



КОМПАНИЙН БҮТЭЦ

“Багануур” ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 07 тоот тогтоолоор Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн тогтоож, Гүйцэтгэх захирлын 2025 оны А/118 тоот тушаалаар 2025 оны орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталж 1 ерөнхий инженер, 3 менежер, 4 газар, 7 хэлтэс, 3 алба, 10 хэсгийн зохион байгуулалттайгаар нийт 1122 ажилтны орон тоотой үйл ажиллагаагаа явуулсан.



УДИРДЛАГЫН БҮТЭЦ



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Т.ОТГОНБОЛД



Ерөнхий инженер
М.МӨНХЖАРГАЛ



Бүтээмж хариуцсан менежер
Д.ГАНТУЛГА



Хяналт хариуцсан менежер
Ц.ОДОНТУНГАЛАГ



Засаглал хариуцсан менежер
Ш.БАТСАЙХАН



Техникийн бодлогын
газрын дарга
А.ЭНХБОЛД



Үйлдвэр технологийн
газрын дарга
Ч.НАРАНБАТ



Стратеги, хөгжлийн
газрын дарга
Д.ДАВААДАШ



Санхүүгийн удирдлагын
газрын дарга
А.ТЭМҮҮЛЭН



Бизнес хөгжил, эрсдэлийн
удирдлагын хэлтсийн дарга
Я.ОТГОНБААТАР



Төслийн удирдлагын
хэлтсийн дарга
Э.ГАНБАТ



Нагтлан бодох бүртгэлийн
хэлтсийн дарга
Ж.БОЛД-ЭРДЭНЭ



Худалдан авалт, хангамжийн
хэлтсийн дарга
Ц.ЭНХБАТ



Захиргаа, хүний нөөцийн
хэлтсийн дарга
Ц.УРАНБИЛЭГ



ХАБЭА, байгаль орчны
хяналтын хэлтсийн дарга
Д.НЯМДАЛАЙ



Үйлдвэр зохион
байгуулалтын албаны дарга
Т.БЯМБАЖАРГАЛ



Мэдээлэл технологийн
албаны дарга
Т.ЭРДЭНЭ-ОЧИР



Дотоод хяналтын
албаны дарга
Б.ХАЖИДМАА


ХҮНИЙ НӨӨЦ

СТАТИСТИК МЭДЭЭ

2025 онд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, стандарт, дүрэм журам, бизнес төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу үндсэн 1122 ажилтны орон тоотой ажилласан. Үүнээс эрэгтэй 971, эмэгтэй 151, жирэмсний амралттай 15 ажилтан байна. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд 826, хэвийн нөхцөлд 296 ажиллаж байна. Албан тушаалын ангиллаар нь авч үзвэл удирдах албан тушаалтан 2%, мэргэжилтэн 3%, инженер техникийн ажилтан

7%, дэд мэргэжилтэн 5%, туслах ажилтан 2%, үйлчилгээний ажилтан 10%, мэргэжлийн ажилтан 71%-ийг эзэлж байна. Боловсролын түвшний хувьд дээд боловсролтой 38%, бүрэн дунд 47%, тусгай дунд 11%, бүрэн бус дунд 4%-ийг тус тус эзэлж байна. Үүнээс 71 ажилтан магистр, 25 ажилтан мэргэшсэн, 7 ажилтан зөвлөх инженер, 2 ажилтан докторын зэрэгтэй байна.


ХҮЙСИЙН ХАРЬЦАА



АЖИЛЛАСАН ЖИЛ



НАСНЫ АНГИЛАЛ



2025 ОНД ШИНЭЭР АЖИЛД ОРСОН АЖИЛТНУУДЫН ТОО



ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА


Компанийн хэмжээнд гаралтын коэффициент 6.6 хувьтай байна. Үүнээс өндөр насны тэтгэвэр - 23, сахилгын шийтгэлээр - 9, өөрийн хүсэлтээр - 29, мэргэжлээс шалтгаалах өвчний групп-8, бусад шалтгаанаар 5 ажилтан тус тус ажлаас гарсан байна.

ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТВОРЖИЛТЫН КОЭФФИЦИЕНТ

Хүний нөөцийн тогтворжилтын коэффициент - 94.3 хувьтай байгаа нь харьцангуй сайн үзүүлэлт бөгөөд байгууллага хүний нөөцөө үр ашигтай удирдаж байгааг харуулж байна.

СУРГАЛТ ХӨГЖИЛ

№	Сургалтын нэр	Давтамж	Хүний тоо	Сургалтын зардал
1	Ажилтнуудын ерөнхий мэдлэг, ур чадвар дээшлүүлэх	52	2452	6,200
2	ИТА нарын мэргэжил дээшлүүлэх	21	268	63,074
3	Ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх	48	1621	31,339
4	Тусгай эрх олгох, эрх сунгах сургалт	16	584	39,402
5	Туршлага судлах	1	65	24,278
6	Бусад зардал			4,592
	Нийт дүн	168	4990	168,855



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙН СУРГАЛТ

ХАБЭА-н сургалт: Шинээр орсон - 109, өөр ажлын байранд шилжсэн - 474, давтан сургалт - 61, зорилтот үзлэгээр 2 удаа, ээлжит үзлэгээр 4 удаа сургалтын хяналт хийгдсэн

Зааварчилгаа, АА-ны хурал: Урьдчилсан зааварчилгаа - 164 ажилтан, оюутан, ажлын байрны зааварчилгаа - 474 ажилтан, АА хуралд давхардсан тоогоор 14018 ажилтан хамрагдсан.

Эрсдэлтэй ажлын байрны сургалт: Цахилгааны АА-ны сургалтад нийт 314 ажилтан хамруулж, шалгалт авч ажиллах эрхийг нь баталгаажуулсан

Дасгал сургуулилт /ЭАШТ, АУД, ГЭД/: 45 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 3821 ажилтныг хамруулсан

Гэрээт, зочдын зааварчилгаа: Гадны зочин 1286 хүнд АА-ны зааварчилгаа, гэрээт ААНБ-ын ажилтнуудад ХАБЭА-н заавар журам танилцуулсан

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН


УУЛЫН АЖИЛ:

2025 онд 4825.0 мян.тн нүүрс олборлон, борлуулахын тулд 22310.0 мян.м³ хөрс хуулан, нийт 32198.1 мян.м³ уулын ажил хийхээр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 4830.7 мян.тн нүүрс олборлон 100.1%, 22889.7 мян.м³ хөрс хуулж 102.6%, 33562.1 мян.м³ уулын ажил хийж 104.2%-ийн гүйцэтгэлтэй ажилласан.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 он				2024 он	Зөрүү
		Төл	Гүйц	Хувь	Зөрүү		
Нүүрс олборлолт	мян.тн	4825.0	4830.7	100.1%	5.6	4957.4	-126.75
Борлуулалт	мян.тн	4825.0	4844.8	100.4%	19.8	4916.0	-71.29
Хөрс хуулалт	мян.м ³	22310.0	22889.7	102.6%	579.7	19183.2	3706.5
Хөрс хуулалтын коэф	м ³ /тн	4.62	4.74	102.5%	0.1	3.87	0.87
Нийт уулын цул	мян.м ³	32198.1	33562.1	104.2%	1364.0	30633.1	2929.06

НҮҮРС ОЛБОРЛОЛТ:


Эрчим хүчний хэрэглээ жилээс жилд өссөн нэмэгдэж байгаа энэ цаг үед 2025 онд 4,825.0 мян.тн нүүрс олборлохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 4830.7 мян.тн нүүрс олборлож төлөвлөгөөгөө 100%-аар биелүүлсэн.



НҮҮРС БОРЛУУЛАЛТ:


Хэрэглэгчдээс ирсэн захиалга, өмнөх жилүүдийн тоон үзүүлэлтэд тулгуурлан 2025 онд 4,825.0 мян.тн нүүрс борлуулахаар төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 4,844.8 мян.тн нүүрс нийлүүлж төлөвлөснөөс 19.8 мян.тн-оор илүү борлуулалт хийж ажилласан.

Хэрэглэгчид	2025 онд				
	2024 он	Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
ДЦС-4	2,388.3	2,385.0	2,433.6	102.0	48.6
ДЦС-3	1,581.8	1,450.0	1,390.2	95.9	(59.8)
ДЦС-2	282.0	282.0	258.2	91.6	(23.8)
ДДЦС	153.2	164.0	189.1	115.3	25.1
ЭДЦС	18.1	20.0	21.6	108.2	1.6
Багануур ДС	67.6	74.4	56.0	75.3	(18.4)
Налайх ДС	37.2	37.7	34.1	90.4	(3.6)
Амгалан ДС	45.3	155.0	129.1	83.3	(25.9)
Төв чандмань ДС	28.9	38.8	23.4	60.3	(15.4)
Сэлэнгэ энерго ДС	37.1	47.8	38.3	80.1	(9.5)
Хөтөл ДС	6.6	-	8.7	-	8.7
Хэнтий ДС	19.5	-	22.3	-	22.3
Бусад	248.4	170.3	241.1	141.6	70.8
Нийт дүн	4,914.2	4,825.0	4,845.7	100.4	20.7



ХӨРС ХУУЛАЛТ:

Жилийн эхнээс 22,310.0 мян.м³ хөрс хуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 22,889.7 мян.м³ буюу 103% гүйцэтгэлтэй ажилласан. Нийт хөрс хуулалтын ажилд авто тээвэртэй хөрс хуулалт 20,989.7 мян.м³, тээвэргүй хөрс хуулалт 1,639.5 мян.м³-ийн гүйцэтгэлтэй байна. Тээвэртэй ашиглалтын системээр нийт хөрс хуулалтын ажлын 91.7%-ийг, тээвэргүй хөрс хуулалтын системээр 7.16%-ийг гүйцэтгэсэн байна. Хөрс хуулалтын коэффициент 0.13-аар өссөн шалтгаан төлөвлөгөөнөөс 580.0 мян.м³-ээр илүү ажил гүйцэтгэсэн.



“БАГАНУУР” ХК НЭГ ХОНОГТ

ВАГОНЫ ТОО

185.5

ВАГОН

ОЛБОРЛОЛТ

13.2

МЯН.ТН

БОРЛУУЛАЛТ

734.8

САЯ.ТӨГ



САНХҮҮГИЙН ҮР ДҮН

НИЙТ ОРЛОГО

“Багануур” ХК нь 2025 онд станцуудад борлуулах эрчим хүчний нүүрсний үнийг ЭХЗХ-оос 2024 оны 12-р сарын 06-ны өдрийн №694 тогтоолоор гаргасан 54,091 төгрөгөөр бизнес төлөвлөгөөг батлуулсан боловч 2025 оны 4-р сарын 02-ний өдрийн Эрчим хүчний зохицуулах хорооноос №167 тогтоолоор 4 сарын 1-нээс хэрэгжүүлэх 1тн нүүрсний үнийг 5 хувь бууруулан 51,386 төгрөгөөр борлуулах шийдвэр гарсан. Тайлант онд үндсэн үйл ажиллагаанаас 262,734.7 сая, үндсэн бус үйл ажиллагаанаас 1,206.3 сая, нийт 263,940.9 сая төгрөгийн орлого олохоор төлөвлөж гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогоос 267,054.9 сая, үндсэн бус үйл ажиллагааны орлогоос 1,183.3 сая, нийт 268,238.2 сая төгрөгийн орлого олж 101.6 хувийн гүйцэтгэлтэй ажилласан.

ОРЛОГО	ЗАРДАЛ	ТТӨАШИГ	ЦЭВЭР АШИГ
268.2	265.4	2.7	1.9
ТЭРБУМ.ТӨГ	ТЭРБУМ.ТӨГ	ТЭРБУМ.ТӨГ	ТЭРБУМ.ТӨГ

НИЙТ ЗАРДАЛ

Компани 2025 онд 263,833.5 сая төгрөгийн зардал гарган 107.5 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 265,485.8 сая төгрөгийн зардал гарган, 2,752.4 сая төгрөгийн ашигтай ажиллаа.

Зардлыг эзлэмжээр нь авч үзвэл нийт зардлын 34.0%-ийг хөдөлмөрийн зардал, 17.4%-ийг шатах тослох материалын зардал, 5.3%-ийг эрчим хүчний зардал, 16.5%-ийг сэлбэг материалын зардал, 15.5%-ийг үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, Санхүүгийн зардал 5.0% /татвар-3.4%, зээлийн хүү-1.6%/, 5.9%-г бусад зардлууд эзэлж байна.

2023	2024	2025
222.1	240.2	265.4
ТЭРБУМ.ТӨГ	ТЭРБУМ.ТӨГ	ТЭРБУМ.ТӨГ

**2026 ОНЫ 01-Р САРЫН 01-НИЙ ӨДРӨӨС
ҮНДСЭН ЦАЛИНГ 10%-ААР НЭМЭГДҮҮЛНЭ**



ХУДАЛДАН АВАЛТЫН ҮР ДҮН

2025 онд тендер зарлах ажлыг бизнес төлөвлөгөө батлагдсан даруйд цаг алдалгүй шуурхай зохион байгуулж ажилласан.

Компанийн 2025 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд 85 тендер зарлахаар төлөвлөж 81 тендер цахимаар зарлаж 76 нь амжилттай болж гэрээ байгуулсан, 5 тендер амжилтгүй 4 тендер зарлаагүй бөгөөд нийт дүнгээр 93.8% гүйцэтгэлтэй ажилласан.

2025 ОНД ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР 1.2 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН БАРАА МАТЕРИАЛЫГ ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧДЭЭС ХУДАЛДАН АВСАН.

АЖЛЫН ХУВЦАС **426.2** “Урбан жийнс” ХХК
сая.төг

АЖЛЫН ГУТАЛ **270.3** “Бестшүес” ХХК
сая.төг

ЭРҮҮЛЖҮҮЛЭХ
БҮТЭЭГДЭХҮҮН **77.2** “Санжайн хишиг” ХХК
сая.төг

ТЭРБУМ МОД
/Хархорум/
модны суулгац **430.0** “Соёолж” ХХК
сая.төг “Ургамалын далай” ХХК

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮН

“Багануур” ХК 2025 онд нийт 50,326.2 сая төгрөгийг хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 45,589.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.

Өөрийн хөрөнгөөр Хөрс хуулалтын өндөр хүчин чадалтай LIEBHERR 9250 маркийн 15м³-ийн шанагатай шууд утгуурт цахилгаан экскаватор болон Нүүрс тээврийн 11.5 м³-ын шанагатай гидро экскаватороор техникийн шинэчлэл хийлээ.

18.4

ТЭРБУМ.ТӨГ



**ЗАСВАРЫН ХЭСГИЙН
ХАМТ ОЛОН ЭШ 10/70
ЭКСКАВАТОРЫН
8 ДАХЬ ШАНАГАА
ҮЙЛДВЭРЛЭВ.**



ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

НҮҮРС ПИРОЛИЗЫН ҮЙЛДВЭР “ХӨХ НҮҮРС” төслийн гүйцэтгэл



Багануур ҮТП-ийн газрын асуудлыг шийдвэрлэх

НИТХ-ын 2025 оны 02-р сарын 26-ны тогтоолыг үндэслэн ЗГ-ын 2025 оны 03-р сарын 20-ны тогтоолоор 2 байршилд 636 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан.



Нүүрс-пиролизын үйлдвэрийн төслийн олон улсын нээлттэй тендерийг зарлаж, шалгаруулж ТЭЗҮ, зураг төслийн ажлыг дуусгах

Ажлын хэсгийн боловсруулсан тендерийн даалгаврыг үндэслэн олон улсын нээлттэй тендерээр БНХАУ-н “SEDIN ENGINEERING” компани шалгарч ТЭЗҮ боловсруулах ажлыг “Эрдэнэс Монгол” нэгдлээс санхүүжүүлэн 4-12-р сарын хугацаанд гүйцэтгэж дууссан. Төслийн ТЭЗҮ, зураг төслийг АҮЭБЯ-ны ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн батлуулахаар шинжээч нар томилогдон ажиллаж байна.



Нүүрс-пиролизын үйлдвэрийг нүүрсээр хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх

“Эрдэнэс Монгол” ХХК болон “Багануур” ХК-ийн хамтарсан ажлын хэсгийг байгуулж нийт 218.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын тооцоог гаргаж 2026-2030 онд үе шаттайгаар шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.



Хагас кокс

600.0

МЯН.ТН


Эрчим хүч

40 МВТ

Хөрөнгө оруулалт	136 сая.доллар
Орлого	77 сая.доллар
Ашиг	14 сая.доллар
ХО нөхөх хугацаа	8.3 жил
Ажлын байр	421



ЛАБОРАТОРЫН ТҮРШИЛТ 2025.01



ТЕХНОЛОГИЙН ТҮРШИЛТ 2025.08



ХАГАС ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТҮРШИЛТ 2026.03

БАГАНУУРЫН НҮҮРСНИЙ ҮНЭ

Эрчим хүчний станц

51.3 МЯН.ТӨГ

Өрхийн хэрэгцээнд

60.0 МЯН.ТӨГ

НҮҮРС-ПИРОЛИЗЫН ҮЙЛДВЭР

66.0 МЯН.ТӨГ




“НҮҮРС БУТЛАН АЧИХ БАЙГУУЛАМЖ №3” ТӨСӨЛ

НБАХ №03 шинээр барих төсөл хэрэгжсэнээр нүүрс борлуулалтын хүчин чадал нэмэгдэж нэг вагон ачих хугацааг 1.5-2.2 минутад ачиж, цагт 1500 тн нүүрсийг бутлан, жилд 8.0 сая.тн хүрнэ. 50 вагонтой цувааг 2.5-3.0 цагт буюу нэг ээлжинд 200 вагон ачина.

Төслийн талбайн байршлыг 3 хувилбараас тооцож НБАБ №01-ийн хажууд байршуулах, Төмөр замын трассыг 5 хувилбараас тооцож үр ашигтай хувилбарыг оновчлон сонгосон.

Хийгдэх ажил	Төсөв /тэрбум.төг/
Тоног төхөөрөмж	26,5
Цахилгаан автоматжуулалт	3,12
Барилга угсралт	6,82
Төмөр зам	18,3
Нийлбэр дүн	54,8
Магадалшгүй зардал (10%)	5,5
Нийт төсөв	60,2



**2025 ОНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН
НЭГДСЭН ХОРООТОЙ БАЙГУУЛСАН
ХАМТЫН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙГ
98.99%-ТАЙ ДҮГНЭЖ, 2026, 2027 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ 7 БҮЛЭГ, 115 ЗААЛТ
БҮХИЙ “ХАМТЫН ГЭРЭЭ”-Г БАЙГУУЛЛАА.**



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

“Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 10:00 цагт “Эрдэнэс Монгол” ХХК-ийн байранд хуралдав. Хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг хувьцаа эзэмшигчдээс брокерын пүүсүүдээр дамжуулан хуралд оролцох санал ирээгүй, 20,147,438 ширхэг хувьцааг төлөөлж 6 хүн итгэмжлэлээр, 1496 ширхэг хувьцаа эзэмшигч 11 хүн өөрийн биеэр нийт 20,148,934 хувьцаа эзэмшигч оролцож хурал 96,06 хувийн ирцтэй хуралдаж дараах шийдвэрүүдийг гаргав.

1. Багануур ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн

талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж 100%-ийн саналаар батлав.

2. Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэж 99,9%-ийн саналаар батлав.

3. Компанийн дүрмийн 3.1.6 дэх хэсэг, 3.5.1 дах хэсэг, 3.3.2 дэх хэсэгт өөрчлөлт оруулан 100%-ийн саналаар батлав.

4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох кумулятив аргаар санал хураалт явуулж Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар сонгов.

75.0%

“ЭРДЭНЭС МОНГОЛ”
ХХК

21.06%

МОНГОЛИАН КОАЛ
КОРПОРЕЙШН

3.94%

ЖИЖИГ ХУВЬ/
ЭЗЭМШИГЧ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хурлаар ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай Компанийн тухай хуулийн 62-р дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, “Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 07,08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУЗ-ийн гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэй сонгосон.



A woman in a dark suit and blue top is standing and speaking into a microphone.

A man in a dark jacket is sitting at the table, looking towards the speaker.

A man in a dark vest and light shirt is sitting at the table, looking towards the speaker.

A long table covered with a blue cloth is set up for a meeting. It has several water bottles, papers, and small flags on it. The chairs are white with blue accents.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

ПҮРЭВДОРЖИЙН БАТТӨР

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд

ЧУЛУУНБААТАРЫН ДОНДОГМАА

БАЛЖИННЯМЫН ГЭРЛЭЭ

ИЧИНХОРЛООГИЙН ЛУВСАНЦЭРЭН

ЭРДЭНЭДЭЛГЭРИЙН ТҮВШИН

ГҮНЧИНСҮРЭНГИЙН НАМЧИНСҮРЭН

ЭНХБАЯРЫН ШИЖИР

МӨРДОРЖИЙН ОТГОНБАЯР

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд

ДАНЗАНБАЛЖИРЫН ЭНХЖАРГАЛ

НАМСРАЙН ЗОРИГТСАЙХАН

ӨВГӨНХҮҮГИЙН ГЭРЭЛТ-ОД

СҮХБААТАРЫН ЦОЛМОН

БАТСҮХИЙН ДАВААТОГТОХ

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод

Аудит, эрсдэлийн хороо

Дарга Н.Зоригтсайхан /хараат бус гишүүн/

Гишүүн Ө.Гэрэлт-Од /хараат бус гишүүн/

Э.Түвшин /ердийн гишүүн/

Цалин, урамшууллын хороо

Дарга М.Отгонбаяр /ердийн гишүүн/

Гишүүн Б.Даваатогтох /хараат бус гишүүн/

Д.Энхжаргал /хараат бус гишүүн/

Засаглал, нэр дэвшүүлэх хороо

Дарга Б.Гэрлээ /ердийн гишүүн/

Гишүүн С.Цолмон /хараат бус гишүүн/

Д.Энхжаргал /хараат бус гишүүн/

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“Багануур” ХК нь эрчим хүчний нүүрс олборлох үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд 2025 онд Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хууль, компанийн дүрэм, холбогдох журмын хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж, компанийн засаглал, хяналтын тогтолцоог бэхжүүлэх, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэн ажиллалаа.

ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ, ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХОРООДЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

Компанийн ТУЗ нь 2025 онд төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч 6, хараат бус 5, хувийн хэвшлийн төлөөлөл 2 буюу төрийн төлөөлөл, хараат бус гишүүд болон бусад төлөөллийг тэнцвэртэйгээр багтаасан нийт 13 гишүүний бүтэцтэйгээр ажилласан.

ТУЗ нь дараах 3 хороотойгоор үйл ажиллагаа явуулж байна:

- Аудит, эрсдэлийн хороо
- Засаглал, нэр дэвшүүлэх хороо
- Цалин, урамшууллын хороо

ТУЗ-ийн гишүүд нь уул уурхай, эрх зүй, эдийн засаг, санхүү, төрийн бодлого, удирдлагын чиглэлээр мэргэшсэн бөгөөд тайлант хугацаанд хурлуудад идэвхтэй оролцож, хэлэлцсэн асуудлуудад хараат бус, мэргэжлийн байр сууринаас санал, зөвлөмж гарган, компанийн стратеги, үйл ажиллагаанд бодитой хувь нэмэр оруулан ажилласан.

ТУЗ-ИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ХЭРЭГЖИЛТ:

ТУЗ нь 2025 онд компанийн стратеги бодлого тодорхойлох, компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах, үр ашиг бүтээмжийг нэмэгдүүлэх, компанийн засаглалын үйл ажиллагааг сайжруулах, ТУЗ-ийг чадавхжуулахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд нийт 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 93%-ийн биелэлттэй ажилласан байна.

ТУЗ-ИЙН ХУРАЛ, ШИЙДВЭР:

Тайлант хугацаанд ТУЗ нь нийт 30 удаа хуралдаж, 25 тогтоол баталж, 3 тэмдэглэл гарган компанийн үйл ажиллагаатай холбоотой стратегийн болон үйл ажиллагааны чухал асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Хэлэлцсэн асуудлын үндсэн чиглэл:

- Компанийн бизнес төлөвлөгөө, төсөв, тодотгол
- Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт

- Ногдол ашиг, санхүүжилт
- Байгууллагын бүтэц, орон тоо
- Гүйцэтгэх удирдлагын томилгоо, үнэлгээ
- Хөрөнгийн удирдлага
- Зээлийн санхүүжилт

2025 оны хурлын тоо, хуралдаанд оролцсон байдал:


Үзүүлэлт	Олон улсын сайн туршлага	Багануур ХК-ийн ТУЗ	Үнэлгээ	Эх сурвалж
Хуралдааны давтамж	6-12 удаа (дундаж)	30 удаа	Өндөр идэвхтэй	OECD Principles of Corporate Governance (2023)
Ирц	>75% (сайн)	98%	Хариуцлагатай, идэвх өндөр	OECD Corporate Governance Factbook (2023)
Шийдвэрийн хэрэгжилт	>80% (үр дүнтэй)	83%	Үр дүнтэй	OECD Principles of Governance (2023)
Хэлэлцсэн асуудал	60-100 (дундаж)	>68+	Өндөр ачаалалтай	Нийт хурлын ба хэлэлцсэн асуудлын тоо

OECD Principle of Corporate Governance (2023)- Хуралдааны давтамж нь компанийн үйл ажиллагаа, салбарын онцлогоос хамааран өөр өөр байх боломжтой бөгөөд жилийн хугацаад 6-12 удаа хуралдах нь нийтлэг жишиг хэмээн дурдсан.

“Багануур” ХК-ийн ТУЗ нь 2025 онд 30 удаа хуралдаж, 98 хувийн ирцтэйгээр 25 тогтоол, 3 тэмдэглэл, 2 удирдамж баталсан нь олон улсын жишигт нийцсэн идэвхтэй үйл ажиллагааны түвшнийг харуулж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь асуудал бүрийг хороодын дүгнэлт, олон улсын сайн засаглалын зарчим, судалгаа, төрийн бодлого шийдвэрт нийцүүлэн хэлэлцэж, шийдвэрлэсэн.

Хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэрийг хувиар харуулбал дараах байдалтай байна.



ТУЗ-ИЙН ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ Аудит, эрсдэлийн, Засаглал, нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороотойгоор үйл ажиллагаагаа явуулсан.

Нэр дэвшүүлэх хороо тайланд хугацаанд 5 удаа хуралдаж дараах асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргаж ажилласан байна. Үүнд:

- Байгууллагын бүтэц, орон тоо
- ТУЗ-ийн бүрэлдэхүүн
- Гүйцэтгэх удирдлагын томилгоо
- Гүйцэтгэлийн үнэлгээ

Аудитын хороо тайлант хугацаанд 8 удаа хуралдаж дараах асуудлаар дүгнэлт, зөвлөмж гарган, компанийн санхүүгийн сахилга бат, хяналтыг сайжруулах чиглэлээр санал санаачилга гарган ажилласан байна. Үүнд

- Санхүүгийн тайлан, ногдол ашиг
- Аудитор сонгон шалгаруулалт
- Бизнес төлөвлөгөө, төсөв, хөрөнгө оруулалт
- Зээлийн санхүүжилт
- Хөрөнгийн удирдлага

Цалин урамшууллын хороо тайлант хугацаанд 3 удаа хуралдаж, дараах асуудлаар дүгнэлт, зөвлөмж гарган, гүйцэтгэлд суурилсан урамшууллын бодлогыг боловсронгуй болгох чиглэлээр ажилласан байна. Үүнд:

- Гүйцэтгэх захирлын үнэлгээ
- Ажилтнуудын урамшуулал
- Цалингийн жишиг

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ


“Багануур” ХК нь Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээг жил бүр хийдэг бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооны Компанийн засаглал, комплаенсийн хэлтсээс тухай бүр нь хянан баталгаажуулдаг. “Багануур” ХК кодексийн хэрэгжилтийн үнэлгээгээр Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компаниудаас 2024 онд 76,4%-ын үнэлгээгээр 14-р байранд эрэмбэлэгдэж байсан бол 2025 оны эхний хагас жилийн байдлаар 84.7%-ийн үнэлгээгээр 10-р байранд эрэмбэлэгдсэн байна.

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛ (БОНЗ), ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАГНАЛ

“Монголын хөрөнгийн бирж” ХК 2022 онд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын тогтвортой санхүүгийн холбоо (ТоС Холбоо), Олон улсын санхүүгийн корпорац зэрэг байгууллагуудтай хамтран ESG буюу БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын удирдамжийг баталсан.


“Багануур” ХК нь 2025 онд анх удаа уг удирдамжийн дагуу БОНЗ, тогтвортой байдлын тайлан гаргаж Монголын хөрөнгийн бирж ХК-д хүргүүлж, биржийн цахим хуудсанд байршуулсан.

ХУВЬЦААНЫ ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ



**2024 ОНЫ КОМПАНИЙН ЦЭВЭР
АШГААС ТАЙЛАНТ ОНД НЭГЖ
ХУВЬЦААНД 23.62 ТӨГРӨГ БУЮУ
НИЙТ 495.5 САЯ ТӨГРӨГИЙН
НОГДОЛ АШГИЙГ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДЭДЭЭ ОЛГОЛОО.**





ISO 45001:2018
**“Хөдөлмөрийн аюулгүй
байдал, эрүүл ахуйн
менежментийн
тогтолцоо” стандартын
баталгаажуулалтын
гэрчилгээг сунгав.**

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

“Багануур” ХК 2025 онд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны үйл ажиллагаатай холбоотой Монгол Улсын хууль, стандарт, дүрэм, журмыг мөрдүүлэх, менежментийн тогтолцоо, бодлогыг хэрэгжүүлэх, ажилтнуудыг зөв хандлага, арга барилд сургах, эрүүл мэндийг нь хамгаалах, ажлын байр, орчны эрсдэлийг үнэлж бууруулах, сөрөг хүчин зүйлийг хэмжих, арилгуулах, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хянах, бууруулах, төлөвлөгөөг гарган ажилласан.


“Багануур” ХК нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.2 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны бодлого (2024-2028), Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO 45001:2018 стандарт шаардлага, компанийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн хүрээнд тайлант хугацаанд бодлогын баримт бичиг / Багануур ХК-ийн ХАБЭАБО-ны бодлого 2024-2028, ISO 45001:2018 стандартын хамрах хүрээ/, 25 журам /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчинтой холбоотой/ шинэчлэн боловсруулж, батлуулан үйл ажиллагаандаа мөрдөж эхэлсэн.

МАГАДЛАН АУДИТ

Менежментийн тогтолцооны MNS ISO/IEC 17021 стандартын дагуу итгэмжлэгдсэн баталгаажуулалтын эрх бүхий “Мон-Сертф” ХХК-ийн аудиторууд ISO 45001:2018 стандартын магадлан аудитыг 2025 оны 8 дугаар сард хийж, “давуу тал 2, сайжруулах боломж 2, анхаарах хэсэг-6, жижиг, том үл тохирол гараагүй, менежментийн тогтолцоо, түүний гүйцэтгэл тасралтгүй сайжирч байгаа, хүлээгдэж буй үр дүнд хүрэх чадвартай” гэж дүгнэн ISO 45001:2018 стандартыг амжилттай нэвтрүүлж байна гэж үзээд “БАТАЛГААЖУУЛАЛТ”-ыг сунгасан.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЭЭЛЖИТ ҮЗЛЭГ:

2025 онд компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ээлжит III шатны үзлэгийг улирал бүр хийж, 206 зөрчил илрүүлсэн нь өнгөрсөн оноос 17.3% буурсан, зөрчил арилгах албан шаардлагыг хэлтэс, хэсэг, нэгжийн удирдлагад өгч, илэрсэн зөрчлийн 97%-ийг бүрэн арилгуулсан, албан шаардлага, зөвлөмжийн хариуг хугацаанд нь өгөх байдал хангалтгүй байсныг хэлтэс, алба, хэсгийн удирдлагуудад анхааруулж ажилласан.

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЙН ТОО, АРИЛГАЛТ /2021-2025 он/**ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ:**

Хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт хийх батлагдсан хэмжилтийн төлөвлөгөөний дагуу 98 ажлын байранд ажлын байрны шуугиан, доргион, бичил цаг уурын үзүүлэлтүүд болох агаарын урсгалын хурд, температур, харьцангуй чийглэг, гэрэлтүүлэг мөн гагнуурын утаа, тоосонцор /PM4, PM10/, агаарын чанарын зарим үзүүлэлтүүдийг шууд хэмжилтийн багажаар, нэг хүнд ноогдох талбай, эргономикийн эрсдэлийг хяналтын хуудас болон ажиглалт, тооцооллын аргаар хэмжиж үнэлэн хүйтний болон дулааны улиралд давхардсан тоогоор 372 удаа хэмжилт, үнэлгээ хийж, мэдээллийн санг үүсгэсэн.

Хэмжилтээр стандартын шаардлагад үл нийцсэн 62 сөрөг хүчин зүйлийг 49 ажлын байранд илрүүлэн холбогдох хэсэг, нэгжийн удирдлагыг мэдээллээр ханган сөрөг хүчин зүйлсийг бууруулсан.


ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДАЛТЫГ БУУРУУЛАХ, ӨВЧЛӨЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

Амбулатороор 1400 гаруй ажилтныг үзэж зөвлөгөө өгч, эмчилгээ сувилгаанд хамруулж, хяналтын бүлгийн 180 ажилтныг шаардлагатай үзлэг шинжилгээнд хамруулан эрүүлжүүлэх төлөвлөгөө гаргасан.

Үүнээс эмчилгээнд хамруулсан 80%, архаг өвчний намжмал буюу сэдэрэлт өгөөгүй 20% байна.

Дүүргийн эрүүл мэндийн төвийн уламжлалт нөхөн сэргээх тасагтай хамтран стационарт хэвтэн эмчлүүлэх шаардлагатай 60 гаруй хүнийг хэвтүүлэн эмчлүүлсэн.

Хөдөлмөрийн чадвар түр алдалт өнгөрсөн 2024 оноос 3%-аар буурсан.

ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДАЛТ /2021-2025 он/**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН УЛСЫН АЛБАНД ЗОХИОН БАЙГУУЛЖ БҮЙ ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГ “БАГАНУУР” ХК-НД БОЛЛОО.**


- Онцгой байдлын ерөнхий газрын Хурандаа А.Дашнямаар ахлуулсан ажлын хэсэг “Багануур” ХК-д ирж үзлэг, шалгалт хийсэн.
- Ажлын хэсэг Багануур ХК-ийн Гамшгаас хамгаалах штабын үйл ажиллагаа, мэргэжлийн ангиудын томилгоо, зохион байгуулалт, хүн нэг бүрийн аранзны үзлэг, мэргэжлийн ангийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, нүүлгэн шилжүүлэх болон тусгаарлах байр, галын аюулгүй байдлын стандартын хэрэгжилт, гал унтраах бэлэн байдал, гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохио дамжуулах төлөвлөлт, техник хэрэгслийн бэлэн байдал зэргийг үзэж, гамшгаас хамгаалах төлөвлөлт, удирдлага зохион байгуулалтын баримт бичиг зэргийг шалгасан ба үзлэгээр “Багануур” ХК 91.4 үнэлгээтэй шалгагдсан.



БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

“Багануур” ХК нь байгаль орчныг хамгаалах, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжих ажилд нийт 737.2 сая.төг зарцуулсан байна.

АГААРЫН ЧАНАР: Агаар дахь бохирдуулагч бодис болох азотын давхар исэл NO₂, хүхрийн давхар исэл SO₂-ын шинжилгээг улирал бүр Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатороор хийлгэсэн. Шинжилгээгээр агаарын бохирдлын хэмжээ стандартаас хэтрээгүй.



ЦАЦРАГ ИДЭВХИЖИЛ: 2025 онд 11 цэгт агаарт болон хөрсөнд цацраг тунгийн чадал /мкЗв/цаг/-ын хэмжилтийг хийлгэсэн. Хэмжилтээр агаар болон хөрсөн дээр цацрагийн агууламж хэвийн хэмжээнд гарсан байна.

ТООСЖИЛТ: Орчны тоосжилтыг агаарын чанарын индексээр үнэлэхэд: 2025 онд стандарт түвшингээс хэтрэлттэй бага зэргийн бохирдолтой 2 тохиолдол байгаа бөгөөд энэ нь 1-р сард дүүргийн төв болон задгай хэсэгт хэтэрсэн байна. Бусад цэгүүдэд стандарт түвшингээс хэтрээгүй.

Агаар дахь тоосжилтын бохирдолд замын тоос хамгийн их нөлөөлдөг. Тоосжилтыг бууруулах гол ажил бол зам засвар, зам усалгаа юм. 2025 онд 34 км замыг хайргаар хучиж, 94.5км замыг 6.3тн усаар усалсан бна.

УС ШҮҮРҮҮЛЭЛТ, УСНЫ ЧАНАР: 2025 онд 6 сая.м3 усыг шавхан зайлуулж, усны төлбөрт 985.8 сая төгрөг төлсөн байна. Үүнийг Багануурын дулааны станцад, нүүрсний гал дарах, замын тоосжилт дарах, мод бутны усалгаа, гол нуурыг нөхөн сэргээх тэжээхэд зарцуулж байна.

ГОЛ, НУУР НӨХӨН СЭРГЭЭСЭН УСНЫ ХЭМЖЭЭ

952531м³
Хужиртын
гол

387490м³
Хуцаагийн
гол

1500м³
Багагүн
нуур

Газрын доорхи болон гадаргын усанд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний хүрээнд гадаргын усны дээжийг 8 удаа, гүний усны дээжийг 30 удаа авч Геологийн төв лабораториор шинжилгээ хийлгэсэн.

ХӨРСӨН БҮРХЭВЧ, ХӨРСНИЙ БОХИРДОЛ: 2025 онд нийт 13 га талбайгаас 38.1 мян.м³ шимт хөрсийг хуулж нөхөн сэргээлтэнд ашиглах зорилгоор шимт хөрсний овоолгуудад байршуулан хадгалсан.



Технологийн автомашинуудыг түлш цэнэглэх үеийн асгаралтаас үүдсэн бохирдсон хөрсийг тухай бүр цуглуулан саармагжуулж байна.

2025 онд нийт 33 цэгээс хөрсний дээж авч 12 дээжинд Нефтийн агууламж, 13 дээжинд агрохими, 8 дээжинд хүнд металлийн агууламжийн шинжилгээг Байгаль орчин хэмжилзүйн төв лабораториор хийлгэсэн.

УРГАМАЛ, АМЬТНЫ АЙМАГ:

БАГАНУУРЫН УУРХАЙН УРГАМАЛЖИЛТЫН ТӨЛӨВ БАЙДАЛ



28
Овог

54
Төрөл

62
Зүйл

Үүнд: Үетэн, нийлмэл цэцэгтэн, буурцагтан, холтсон цэцэгтэн, сарнайн овгууд голлох байр эзэлж байна.

Ургацын байдал цаг агаарын нөхцөлөөс хамаарч харилцан адилгүй байдаг ба 1999 оны ургац 28.4 цн/га, 2007 онд 18.5 цн/га байсан нь хамгийн өндөр, 2015, 2018 онд нөхөн сэргээсэн газрын ургацын масс хамгийн бага буюу 5.9-6 цн/га гарсан.

“Хустайн байгалийн цогцолборт газар” ТББ-тай хамтран Монгол тарваганы тооллого болон дош усалгааны ажил, зан авирын дүн шинжилгээг хийсэн. 2025 оны 4 сард 5 дошны байрлал дээр 7 хоногт 2 удаа усалгааг тогтмол хийснээр дошин дээр ургамлын өнгө сэргэн идээшилт сайжирсан. 6-р сард мөндөл 22, тарвага 36 тоологдсон байна.

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ: Татварын алба, “Багануур тохижилт” ОНӨААТҮГ-тай хамтран Дахин ашиглагдахгүй ахуйн хог хаягдлын гуравласан гэрээг байгуулан хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт зайлуулан хаяж байна. Компанид үүсэж буй хуванцар сав, картон хайрцаг, бичгийн цаас зэргийг хүлээн авч 2025 онд 480кг хаягдлыг Налайх дүүргийн дахивар хүлээн авах цэгт хүлээлгэн өгсөн.

дд	Хог хаягдлын төрөл	хэм / нэгж	2022 он	2023 он	2024 он	2025 он
1	Цаас, картон цаас	кг	232	177.5	465	366
2	Хуванцар	кг	99.5	133	475	231
3	Шил	ш			15	2
4	Гялгар уут	кг			2	



Хог хаягдлыг ангилан ялгах ажлыг хийснээр 2025 онд үйлдвэрийн хог хаягдлаас нийт 33 төрлийн 8898 нэгж хог хаягдлыг дахин ашигласан байна.

Аюултай хог хаягдлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу мэргэжлийн байгууллагуудтай гэрээ байгуулан хүлээлгэн өгсөн. Үүнд: ажилласан тос маслыг “Алтан оршихуй групп” ХХК-д, аюултай хог хаягдал, сав боодлыг “Түмэн эгшиг” ХХК-д хүлээлгэн өгсөн байна.

Мэргэжлийн байгууллагын нэр	Х\нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
Алтан Оршихуй Групп ХХК	л	49,730	Моторын масло
Түмэн эгшиг ХХК	кг	793.9	Тосны шүүр
Түмэн эгшиг ХХК	ш	145	Агаар шүүгч
Нийт		50,668.9	



Ажилтнуудын орох гарах хэсэгт Хаягдал батарей цуглуулах савыг байрлуулан цуглуулж байна.

Оффисын байруудад 25 байршилд батарей хадгалах савуудыг байршуулсан.



ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

**“БАГАНУУР” ХК 2030 ОН ГЭХЭД 1.000.000
МОД ТАРЬЖ УРГУУЛНА.**

ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ:

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжиж хэрэгжүүлэх зорилгоор 2025 онд 52,500 ш мод тарихаар төлөвлөснөөс хаврын тарилтаар 22,303 ш мод бут, намрын тарилтаар 32,906 ш мод бут нийт 55,209 ш мод, буцыг тарьсан.

Модны тоо	2022 он	2023 он	2024 он	2025 он	Нийт
Тарьсан модны тоо	10,000	11637	18700	55209	95546



Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Нийслэлийн байгаль орчноос ирсэн албан хүсэлтийн дагуу Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах нийтийн эзэмшлийн талбайг тохижуулах ажилд оролцсон. Энэхүү ажилд 9 компани хамтран оролцсон бөгөөд 866м2 талбайг зүлэгжүүлэх 270ш мод тарих тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.





**“БАГАНУУР” ХК ШИНЭ
“ХАРХОРУМ” ХОТЫН БҮТЭЭН
БАЙГУУЛАЛТАД ОРОЛЦОЖ**


10000 Ш

ШИЛМҮҮСТ МОД ТАРИЛАА.



ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ:

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд жил бүрийн байгаль орчныг хамгаалах ажлыг тусган боловсруулж Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамаар батлуулан, хэрэгжилтийн тайланг Нийслэлийн байгаль орчны газраас томилогдсон комиссоор дүгнүүлэн ажиллаж байна.



дд	Баримт бичгийн нэр	Хугацаа	Хийгдсэн онууд
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, биелэлтийн тайлан	Жил бүр	1999-2025 он
2	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан	5 жилд 1 удаа	1995 он 2000-2001 он 2006-2007 он 2012-2013 он 2018-2019 он 2024-2025 он
3	Байгаль орчны аудит	2 жилд 1 удаа	2016-2017 он 2019 он 2021 он 2023 он 2025 он





**2.2 ГА ГАЗАРТ АМИНЫ ОРОН СУУЦ,
1.1 ГА ГАЗАРТ НИЙТИЙН ОРОН СУУЦ БАРИХААР
“УУРХАЙЧИН ОРОН СУУЦ ХӨТӨЛБӨР”-ИЙГ
2026 ОНООС ХЭРЭГЖҮҮЛНЭ.**

Онцлох үйл явдлууд

“БАГАНУУР” ХК-ИЙН УУРХАЙЧИН ХАМТ ОЛНЫ ДУНДААС ШИНЭ ГАВЬЯАТ ТӨРЛӨӨ.



Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 114 жилийн ойн өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн зарлигаар Багануур ХК-ийн Засварын хэсгийн дарга Гүрсэдийн Соронзонболд **МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ УУРХАЙЧИН** цол тэмдгээр шагнагдлаа.

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГУРАВЛАСАН САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА



“Багануур” ХК, “Эрдэнэс ҮТП” ХХК, Багануур дүүргийн ЗДТГ-тай хамтран ажиллах гуравласан санамж бичиг байгууллаа.

Санамж бичгийн хүрээнд талууд дараах чиглэлээр ажиллана. Үүнд:

- ҮТП-ийн зориулалтын газрыг Улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг гэрээний дагуу шийдвэрлэхэд хамтран ажиллах;
- Орон нутгийн болон бусад оролцогчдод хүнд үйлдвэрийн салбарын онцлог, салбарын хууль тогтоомж болон бодит үр нөлөөг таниулах;
- ҮТП-д нэн шаардлагатай нарийн мэргэжлийн боловсон хүчнийг



бэлтгэх, сургах зорилгоор өсвөр үеийнхэнд зориулсан “Ирээдүйн инженер” арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх;

- ҮТП-д шаардлагатай хүний нөөц, ажиллах хүчний нөөц бүрдүүлэх чиглэлээр хамтран ажиллах;
- ҮТП-д шаардлагатай ажлын байрны 50-аас доошгүй хувийг орон нутгаас хангах, цаашлаад ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх цогц хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Орон нутагт залуусын шинжлэх ухаан, инновацын төв байгуулах төсөл хэрэгжүүлэх боломжийг судлах;

MINING WEEK & MINEPRO-2025



Монгол Улсын Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Монголын Уул уурхайн Үндэсний ассоциаци хамтран зохион байгуулдаг “Mining Week & MinePro 2025” үзэсгэлэн, чуулга уулзалт Налайх дүүргийн Тайж хайрхны бэлд боллоо.

Уул уурхайн салбарын үйл ажиллагаа, бодлого чиглэл, хөгжил, зорилт төлөвлөгөө, ирээдүйн чиг хандлага зэрэг бүхий л асуудлаа цогцоор нь харж, хэлэлцдэг уул уурхайн 7 хоног дөрөв дэх жилдээ зохион байгуулагдаж байна.

ОЛОН УЛСЫН ISO/IEC 27001:2022 МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО, СТАНДАРТЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТӨСЛИЙГ ЭХЛҮҮЛЛЭЭ



ХБНГУ-ЫН ЭЛЧИН САЙД ХЕЛЬМУТ КУЛИТЦ ТЭРГҮҮТЭЙ ЗОЧИД “БАГАНУУР” ХК-НД ЗОЧИЛЛОО



ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Хельмут Кулитц, Монголыг хариуцсан менежер Яана Керн-Ритонга, суурин төлөөлөгч Юрген Хартвиг, Байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай уул уурхай төслийн удирдагч Хайме Фернандез нар “Багануур” ХК-д зочилж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцан, хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.

НЭГ САЯ КИЛОМЕТР ЗАМ ТУУЛЛАА

Л.Дашдондог даргатай CAT 777D №161 автосамосвалын бригад 2025.10.20-ны өдөр, М.Санжмятав даргатай CAT 777D №162 автосамосвалын бригад 2025.12.29-ны өдөр **НЭГ САЯ** километр зам тууллаа.



МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БААТАРУУД “БАГАНУУР” ХК-Д ЗОЧИЛОО



Хийсэн бүтээсэн алдар гавьяагаа цуурайтуулсан, уул уурхай, аж үйлдвэрийн салбараас, эгэл малчны хотноос, урлагийн алтан тайзнаас, их спортын дэвжээнээс гээд салбар бүрээс төрөн гарсан их үйлсийн эзэд болсон Монгол улсын Хөдөлмөрийн баатар цолтнууд Багануур ХК-нд зочиллоо.

“БИЗНЕС, ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА БА ХЭРЭГЛЭЭ” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ БОЛЛОО.

“Багануур” ХК, Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн сургуультай хамтран “Бизнес, эдийн засгийн судалгаа ба хэрэглээ” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгууллаа.



АХИСАН ТҮВШНИЙ ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫГ ХОЁР ДАХЬ ЖИЛДЭЭ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

“Багануур” ХК, ШУТИС-ийн геологи, уул уурхайн сургуулийн хамтын ажиллагааны хүрээнд ГУУС-ийн магистрант, докторант оюутны 2024-2025 оны хичээлийн жилийн хаврын улирлын эрдэм шинжилгээний ээлжит хурал боллоо. Ахисан түвшний эрдэм шинжилгээний хуралд 4 докторант, 6 магистрант оролцсоны дотор “Багануур” ХК-ийн 3 ажилтан илтгэл хэлэлцүүлээ.



“ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН САН”-ААС ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЖ, ТЭТГЭЛЭГ ОЛГОЛОО



Орон сууцны дэмжлэг 9 ажилтанд нийт 135,0 сая төгрөг, Оюутны сургалтын тэтгэлэг 9 оюутанд нийт 32 сая төгрөг, Эрүүл мэндийн тэтгэмж 4 ажилтанд нийт 20 сая төгрөгийг олголоо.





“ЭРҮҮЛ МЭНД, ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ШИЙДВЭРЛЭЛЭЭ.

ШУТИС-ИЙН ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН СУРГУУЛЬТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА.



“Эрдэс баялгийн салбарын сургалт-судалгаа-хамтын ажиллагааны хөгжил” үндэсний II хэлэлцүүлгийн үеэр “Багануур” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Т.Отгонболд, ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургуулийн захирал К.Хавалболот нар 2026-2027 онд хамтран хэрэгжүүлэх ажлаа төлөвлөн тусгасан санамж бичгийг үзэглэлээ.

Санамж бичиг нь геологи, уул уурхайн салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, хамтарсан сургалт, судалгаа зохион байгуулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, харилцан туршлага солилцох, хүний нөөцийг чадавхжуулах болон бусад чиглэлээр хамтран ажиллах зорилготой.

“ТҮЛХҮҮР МЭДЛЭГ-ТӨГС ГАРАА” СЭДЭВТ ШИНЭ АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТ ӨДӨРЛӨГ

Өдөрлөгт 2024, 2025 онд шинээр ажилд орсон 125 ажилтанд оролцлоо.



ЗХНХ-ЭЭС “МИЗҮ” ЗАРЧМЫГ БАРИМТЛАН, АЖЛЫН БАЙРАНДАА “АЖЛЫН ХУВЦСААРАА ГАНГАРЬЯ” ХЭМЭЭН УРИАЛЖ, ТУГ АЯЛУУЛЖ ЭХЭЛЛЭЭ

МИЗҮ

- Мэндлэх- Өглөө, өдөр, оройн мэндийг мэдэх. Мэндлэх соёлыг хэвшүүлэх.
- Инээмсэглэх- Ус мэт уян хатан байж, харилцааг инээмсэглэн эхэлж инээмсэглэн дуусгах.
- Зөвлөлдөх- Уян хатан сэтгэлгээтэй байж, өөрийн болон бусдын сэтгэл хөдлөлийг хүлээн зөвшөөрч ямар ч асуудал, ажлыг хэлэлцэн зөвлөлддөг байх.
- Үйлчлэх- Компанидаа үйлчлэх буюу компанийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд ажилтан нэг бүр цаг ашиглалтаа сайжруулах.



“ЭМЭГТЭЙЧҮҮД-МАНЛАЙЛАЛ” ӨДӨРЛӨГ



Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Эмэгтэйчүүд-манлайлал” сургалт, өдөрлөгийг зохион байгуулж компанийн шилдэг эмэгтэйчүүдээ шагнаж урамшууллаа.



“ГЭР БҮЛ-АЗ ЖАРГАЛЫН ҮНДЭС” УУРХАЙЧДЫН ГЭР БҮЛИЙН ӨДӨРЛӨГ

Манай компани жил бүр Олон улсын гэр бүлийн өдрийг уурхайчдынхаа гэр бүлүүдтэй хамтдаа тэмдэглэн, нэгэн өдрийг аз жаргалтай өнгөрүүлдэг уламжлалтай. Энэ жил “Гэр бүл-

Аз жаргалын үндэс” сэдвийн дор 150 ажилтнаа гэр бүлийнх нь хамт урьж оролцуулан амьдралынх нь жаргалтай дурсамжид нэгэн хуудас нэмлээ.



УУРХАЙЧИН ЗАЛУУСЫН “АЛТАН НАМАР” ӨДӨРЛӨГ



Уг өдөрлөг нь 18-35 насны залуучуудыг эергээр төлөвшүүлж тэдний идэвх санаачилгыг дэмжихийн зэрэгцээ ажилтнуудын хоорондын харилцаа холбоог өргөжүүлэх, хамтач сэтгэлгээ, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх зорилготой.

E-SPORT CS2 АНХДУГААР ТЭМЦЭЭН



“Багануур” ХК-ийн Залуучуудын зөвлөлөөс санаачлан зохион байгуулсан E-Sport CS2 төрлийн байгууллагын анхдугаар тэмцээн амжилттай зохион байгуулагдлаа.

“УУРХАЙЧИН” БАГИЙН ТАМИРЧИД ОЛС ТАТАЛТЫН ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНИЙ МАСТЕР ЦОЛ ХҮРТЛЭЭ

“Багануур” ХК-ийн “Уурхайчин” багийн тамирчид 2024 онд БНХАУ-д болсон Олон улсын олс таталтын тэмцээний гадна төрөлд холимог багийн алт, мөнгөн медаль, ХБНГУ-д болсон Дэлхийн аваргын тэмцээний гадна төрөлд амжилттай оролцож дурсгалын медаль, 2025 онд Малайз улсад зохион байгуулагдсан ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд холимог багийн төрөлд мөнгөн медаль хүртсэн амжилтаараа 9 уурхайчин тамирчид “Олон улсын хэмжээний мастер” цол тэмдэг хүртлээ.



U12 НАСНЫ УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД “УУРХАЙЧИН” СПОРТ ЦОГЦОЛБОРЫН ДЭРГЭДЭХ ӨСВӨРИЙН САГСАН БӨМБӨГИЙН ЭМЭГТЭЙ БАГ ТАМИРЧИД ТҮРҮҮЛЖ, УЛСЫН АВАРГА БОЛЛОО.



U13 НАСНЫ УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД “УУРХАЙЧИН” СПОРТ ЦОГЦОЛБОРЫН ДЭРГЭДЭХ ӨСВӨРИЙН САГСАН БӨМБӨГИЙН ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ БАГ ТАМИРЧИД ТҮРҮҮЛЖ, УЛСЫН АВАРГА БОЛЛОО.



ӨСВӨРИЙН ХОККЕЙЧИД ОЛОН УЛСЫН ТЭМЦЭЭНЭЭС МӨНГӨН МЕДАЛЬ ХҮРТЛЭЭ



БНСУ-ын Гүми хотод болсон U12 насны ангиллын шайбтай хоккейн Олон Улсын тэмцээнд Монгол улсын өсвөрийн шигшээ баг Мөнгөн медаль хүрсэн амжилт үзүүлжээ. Монгол улсын шигшээ багийн бүрэлдэхүүнд “Багануур” ХК-ийн дэргэдэх Багануур Хоккейн клубийн тамирчин М.Дөлгөөн,

Б.Гэрэлтхүү, Г.Хүслэн нар шалгаран оролцлоо.

ASIAN PACIFIC CUP- 2025 САГСАН БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭНЭЭС ӨСВӨРИЙН ТАМИРЧИД МӨНГӨН МЕДАЛЬ ХҮРТЛЭЭ



Сингапур улсад болсон Ази Номхон далайн орнуудын 13 дахь удаагийн цомын аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээний U12 насны охидын ангилалд Монгол улсын шигшээ баг Мөнгөн медаль хүртсэн байна. Монгол Улсаас U12 насны охидын ангилалд оролцсон “Eureka” багийн бүрэлдэхүүнд Багануур

ХК-ийн “Уурхайчин” спорт цогцолборын тамирчин У.Ариунгоо, Б.Хулан, Э.Номин-Эрдэнэ нар шалгаран оролцлоо.

БАГАНУУР ДҮҮРГИЙН СПОРТЫН ИХ НААДМЫН ШИЛЖИН ЯВАХ ЦОМЫГ 8 ДАХЬ УДААГАА ХҮРТЛЭЭ

Багануур дүүргийн Засаг даргын нэрэмжит “Хөдөлгөөн-Эрүүл мэнд” IX их наадамд манай хамт олон амжилттай оролцож, спортын 12 төрлөөр өрсөлдөн, 11 төрөлд 121 медаль хүртэж, нийлбэр дүнгээр тэргүүлж, шилжин явах цомыг 8 дахь удаагаа хүртсэн бахархам амжилтыг үзүүллээ.



ОРОН НУТАГ ХАМТЫН АЖИЛГАА

ДҮҮРГИЙН ТӨР ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧГИЙГ ҮЗЭГЛЭЛЭЭ

Санамж бичгийн хүрээнд талууд хамтран Монгол Улсын Засгийн Газрын Хот хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 68 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллана. Мөн “Агаар орчны бохирдол, хог хаягдлыг бууруулах, хүн амын эрүүл мэндийг дэмжих, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хамтран ажиллана.

ХҮҮХДҮҮДЭД БАЙГАЛЬ ОРЧИН, МОД ТАРИХ АРГА, ХОГ ХАЯГДАЛ АНГИЛАХ ТАЛААР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Багануур дүүргийн “Гүн Галуутай” сургуулийн 6-11-р ангийн 1241 сурагчид байгаль орчин, мод тарих арга, хог ангилах талаар, 9 цэцэрлэгийн 718 хүүхдэд танин мэдэхүй, хог хаягдлын сургалтыг зохион явууллаа.

743 ӨРХӨД 186 ТОНН НҮҮРСНИЙ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЛЭЭ



ИРЭЭДҮЙН УУРХАЙЧИН СЭДЭВТ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ ӨДӨРЛӨГ БОЛЛО



Өдөрлөгт Багануур дүүргийн 12 дугаар ангид суралцаж буй 128 сурагч хамрагдлаа.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2025 оны 12 сарын 31-ний өдөр

Багануур ХК

/ төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		2024 оны 12 сарын 31-ний өдөр	2025 оны 12 сарын 31-ний өдөр
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	6,366,982,530.30	7,909,849,201.67
1.1.2	Дансны авлага	4,690,594,574.18	6,932,466,641.03
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	2,640,878.45	153,225,618.46
1.1.4	Бусад авлага	1,951,272,638.91	1,589,896,053.79
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	49,105,511,778.26	50,066,362,235.16
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	2,311,999,968.54	2,570,356,806.63
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн хөрөнгө /борлуулах бүлэг хөрөнгө/	-	-
1.1.10		-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	64,429,002,368.64	69,222,156,556.74
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	168,599,587,652.46	172,378,887,067.49
1.2.2	Биет бус хөрөнгө	4,616,514,877.36	4,409,529,558.10
1.2.3	Уул уурхайн хөрөнгө / УУХөгжүүлэлт, Хөрс хуулалт/	25,169,955,715.80	27,646,923,325.70
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	615,704,292.34	615,704,292.34
1.2.5	Биологийн хөрөнгө мод суулгац	-	577,125,545.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	764,393,387.00	764,393,387.00
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,328,603,776.54	520,020,644.32
1.2.9		-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	201,094,759,701.50	206,912,583,819.95
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	265,523,762,070.14	276,134,740,376.69
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	62,906,234,850.58	71,095,189,392.79
2.1.1.2	Цалингийн өглөг	2,589,819,924.00	2,764,096,203.44
2.1.1.3	Татварын өр	76,622,743,332.17	17,042,145,897.09
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	13,356,223,186.00	137,773,982,106.47
2.1.1.6	Хүүний өглөг	-	8,585,057,907.16
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,550,967,618.04	3,064,264,939.04
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	97,299,473.76	74,777,504.65
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	157,123,288,384.55	240,399,513,950.64

2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	91,243,334,940.28	19,373,897,380.01
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/	1,167,266,443.09	1,167,266,443.09
2.1.2.3	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	9,136,501,019.22	9,365,357,056.95
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	101,547,102,402.59	29,906,520,880.05
2.2	Өр төлбөрийн нийт дүн	258,670,390,787.14	270,306,034,830.69
2.3	Эздийн өмч	2,097,436,000.00	2,097,436,000.00
2.3.1	Төрийн өмч	1,573,077,000.00	1,573,077,000.00
2.3.2	Хувийн өмч	524,359,000.00	524,359,000.00
2.3.4	Халаасны хувьцаа		-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	63,295,572,091.86	63,295,572,091.86
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		-
2.3.8	Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	3,702,426,000.00	3,702,426,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(62,242,062,808.86)	(63,266,728,545.86)
2.3.11	Эздийн өмчийн дүн	6,853,371,283.00	5,828,705,546.00
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	265,523,762,070.14	276,134,740,376.69

ЗАХИРАЛ

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДСОГ



Т.ОТГОНБОЛД

Б.НАРАНБААТАР

Орлогын дэлгэрэнгүй тайлан

Багшнуур ХК

2025 оны 12 сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

№	Өмнөх оны мөн үеийн дүн	Мөнгөн дүн		Заглуулсан	
		2024 оны 12 сарын 31-ний өдөр	2025 оны 12 сарын 31-ний өдөр	Аудитын зөвлөмжөөр	Заглуулсан дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	237,581,225,691.92	267,054,959,058.06		267,054,959,058.06
2	Борлуулалтын өртөг	217,369,427,229.47	239,280,241,332.54		239,280,241,332.54
3	Нийт ашиг (алдагдал)	20,211,798,462.45	27,774,717,725.52		27,774,717,725.52
4	Түрээсийн орлого	45,081,745.46	119,326,218.16		119,326,218.16
5	Хүүгийн орлого	23,265,228.67	69,346,173.78		69,346,173.78
6	Ногдол ашгийн орлого	377,061,963.56	104,981,458.07		104,981,458.07
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-		-
8	Бусад орлого	2,744,391,353.17	889,630,640.31		889,630,640.31
9	Борлуулалт, маркетингийн зардал	694,205,527.44	1,104,521,263.80		1,104,521,263.80
10	Ерөнхий ба удирдлагын зардал	15,975,522,292.00	18,124,508,179.75		18,124,508,179.75
11	Санхүүгийн зардал	4,008,421,198.11	4,348,756,718.60		4,348,756,718.60
12	Бусад зардал	1,335,828,392.78	2,627,802,004.94	(6,912,400.10)	2,620,889,604.84
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	819,020,429.18	-		-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-		-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-		-
16	Хөрөнгө оруулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	-	-		-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-		-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,206,641,772.16	2,752,414,048.75	6,912,400.10	2,759,326,448.85
19	Орлогын татварын зардал	554,984,490.04	849,161,475.47	6,912,400.10	856,073,875.57
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,651,657,282.12	1,903,252,573.28	-	1,903,252,573.28
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-		-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,651,657,282.12	1,903,252,573.28	-	1,903,252,573.28
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-		-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-		-
23.2	Гадаад валютын хөрүүнээс үзэлтийн зөрүү	-	-		-
23.3	Бусад олз (гарз)	-	-		-
24	Орлогын нийт дүн	1,651,657,282.12	1,903,252,573.28	-	1,903,252,573.28
25	Нэгж хувьцаагчид ноогдох хурь ашиг (алдагдал)	-	-		-

ЗАХИРАГ

ЕРӨНХИЙ НИЯТЛАХ БОДИГЧ

Т.ОГТОНБОЛД

Б.НАРАНБААТАР



Өмчийн өөрчлөлтийн тайлан-Залруулсан

Багануур ХК

2025 оны 12 сарын 31-ний өдөр


№	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Галаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эдийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 1-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,097,436,000.00	0.00	0.00	63,295,572,091.86	0.00	3,702,426,000.00	-40,219,530,431.97	28,875,903,659.89
2	Нягтлан болох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл	2,097,436,000.00	0.00	0.00	63,295,572,091.86	0.00	3,702,426,000.00	-40,219,530,431.97	28,875,903,659.89
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
5	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	-23,674,189,659.01	-23,674,189,659.01
6	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
7	Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	1,651,657,282.12	1,651,657,282.12
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
9	2025 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	2,097,436,000.00	0.00	0.00	63,295,572,091.86	0.00	3,702,426,000.00	-62,242,062,808.86	6,853,371,283.00
10	Нягтлан болох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	2,097,436,000.00	0.00	0.00	63,295,572,091.86	0.00	3,702,426,000.00	-62,242,062,808.86	6,853,371,283.00
12	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
13	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
14	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	494,199,906.86	494,199,906.86
15	Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	1,903,252,573.28	1,903,252,573.28
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
17	2025 оны 12 сарын 31-ний өдөр	2,097,436,000.00	0.00	0.00	63,295,572,091.86	0.00	3,702,426,000.00	-63,266,728,545.86	5,828,705,546.00

ЗАХИРАЛ

ЕРӨНХИЙ НИЯГЛАЛТ БОДОЧ

Т.ОТГОНБОЛД

Б.НАРАНБААТАР



Мөнгөн гүйлгээний тайлан

Багануур ХК

2025 оны 12 сарын 31-ний өдөр
/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Тайлант үеийн дүн	Өссөн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	236,751,140,252.90	277,500,976,650.49
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	236,221,865,182.01	277,069,445,701.49
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар	384,739,247.55	393,447,949.76
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	144,535,823.34	38,082,999.24
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	215,058,086,616.04	305,896,876,999.48
1.2.1	Ажиллагчдад төлсөн	48,219,477,862.73	55,657,189,616.30
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	23,876,227,349.56	19,212,086,011.91
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	77,030,502,580.61	89,783,580,454.36
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	104,500.00	-
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	49,102,924,244.98	43,166,757,205.43
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	429,205,919.32	162,821,922.22
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	10,059,756,471.33	85,102,592,307.67
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	6,339,887,687.51	12,811,849,481.59
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	21,693,053,636.86	(28,395,900,348.99)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	23,257,056.10	69,346,173.78
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсаны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсаны орлого		
2.1.5	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	23,257,056.10	69,346,173.78
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	20,602,209,836.06	25,716,090,936.36
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	20,337,117,651.70	25,716,090,936.36
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	265,092,184.36	
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(20,578,952,779.96)	(25,646,744,762.58)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	40,071,275,287.00	110,950,950,810.83
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	40,071,275,287.00	110,950,950,810.83
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	37,235,628,356.79	55,365,439,027.89
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	37,235,569,846.79	55,365,439,027.89
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	58,510.00	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,835,646,930.21	55,585,511,782.94
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	3,949,747,787.11	1,542,866,671.37
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,417,234,743.19	6,366,982,530.30
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,366,982,530.30	7,909,849,201.67

ЗАХИРАЛ

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ



Т.ОТГОНБОЛД

Б.НАРАНБААТАР





Шуудангийн хайрцаг:

12150 Улаанбаатар хот, Багануур дүүрэг, ш/х-554

Хаяг:

Улаанбаатар хот, Багануур дүүрэг 3-р хороо, (Үйлдвэрийн район)

Факс: (976)-70213130

Е-Шуудан: bjsc@baganuurmine.mn

www.baganuurmine.mn